Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

# САНТ СУМЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2020.12.10

Майхан

| № | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг тоо баримтаар товч бичих | Байгууллагын үнэлгээ | Аймгийн ЗДТГазар үнэлгээ |
|---|---|---|---|---|---|
| **УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР** | | | | | |
| 1 | 1.1. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг тус тус аймаг орон нутагт хангуулах, төрийн байгууллагын удирдлагын хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх. | 1.1.1. Сумын Засаг даргаас Төсвийн шууд захирагч нартай байгуулах гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр заалт тусган, үр дүнг тооцох. | Сумын Засаг дарга байгууллагын төсвийн шууд захирагч нартай байгуулсан гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр заалт тусган үр дүнг тооцож байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар авлига, ашиг сонирхлын зөрчил илрээгүй. Иргэдээс гомдол санал ирээгүй. | 100 | |
| | | 1.1.2. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн чиглэлээр Сумдын Засаг даргын Тамгын газар, 21 агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой ААН байгууллагын удирдах албан тушаалтнуудыг арга зүйгээр хангаж, нийт мэдүүлэг гаргагч нарын 2020 онд шинэчлэн гаргах хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулж, мэдээг тайланг АТГ-т хүргүүлэх. | 2020 онд төсвийн байгууллагын дарга нарт хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн чиглэлээр заавар зөвлөмж өгч ажилласан. АТГазрын цахим гарын авлага, видео бичлэгийг сумын хамгийн олон дагагчтай фэйсбүүк бүлгүүдэд байршуулсан. 2020 оны 01-р сард ХАСХОМ гаргадаг 5 төрийн албан хаагчийн шинэчлэн гаргах хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулж, мэдээ тайланг аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн. | 100 | |
| | | 1.1.3. АТҮХөтөлбөрийн төлөвлөгөөг сумын төрийн | Төсвийн байгууллагууд “Авлигатай тэмцэх үндэсний | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байгууллагуудын тайланг ЗДТГазар, төрийн байгууллагуудын тайланг нэгтгэн, 19 сум 22 агентлагт хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлт, үр дүнг тооцох. | хөтөлбөр"-ийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Мэдээ тайланг авч нэгтгэн хугацаанд нь хүргүүлж хэвшсэн. | | |
| | **ДУНДАЖ ОНОО** | | | **100** | |
| **Хоёр. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хүлээсэн төрийн байгууллагын нийтлэг үүрэг** | | | | | |
| | 2.1. Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1. Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх боломж, нөхцөлөөр хангах. | 2.1.1.Үйл ажиллагаандаа ашиглаж буй цахим хуудас албан ёсны сайтад, хэлэлцэгдэж буй хууль, шийдвэрийн төслийг байршуулж, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтийн зүгээс санал, хүсэлт илэрхийлэх бололцоог бүрдүүлэх. | Сумын ашиглах боломжгүй болсон веб сайтыг 1000.0 төгрөгөөр шинэчлэн хийлгүүлсэн. Албан ёсны сайтад, хэлэлцэгдэж буй хууль, шийдвэрийн төслийг цахимд /Фэйсбүүк бүлгүүдэд/ байршуулдаг. | 70 | |
| | | 2.1.2. Авлигатай тэмцэх газраас АТҮХөтөлбөрийн биелэлтийг байгууллагын цахим хуудсанд нэвтрэн үнэлж, дүгнэх болсонтой холбогдуулан төрийн байгууллагууд хийж хэрэгжүүлсэн ажлаа тухай бүр байгууллагын цахим хуудсанд байршуулах ажлыг зохион байгуулах. | Sant.ov.gov.mn цахим хуудсанд АТҮХөтөлбөрийн төлөвлөгөө, биелэлтийн тайланг байршуулсан. | 100 | |
| | 2.2. Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2. Төрийн байгууллага Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, энэ талаарх мэдээллийг | 2.2.1.Байгууллагын цахим хуудсанд авлигын эсрэг 2020 оны төлөвлөгөө, иргэд болон хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудад зориулсан шаардлагатай | Төсөв санхүүгээс шалтгаалан сумын цахим хуудсыг шинээр хийлгэсэн учир одоонoос авлигын эсрэг 2020 оны төлөвлөгөө, иргэд болон хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудад зориулсан шаардлагатай гарын авлага, материалыг байршуулсан. | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах. | гарын авлага, тараах материал бусад мэдээллийг бэлтгэн байршуулж, тогтмол шинэчлэх. | | | |
| | | 2.2.2. Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиудаар үүссэн нөхцөл байдалтай уялдуулан онлайнаар сургалт мэдээлэл өгөх, гарын авлага, шторкыг олон нийтийн сүлжээгээр тараах. | Сумын хамгийн олон дагагчтай фэйсбүүк бүлгүүдэд АТГазрын цахим гарын авлага, видео бичлэгийг байршуулсан. | 70 | |
| | 2.3. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3. Төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах. | 2.3.1. Төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах. | Сумын Засаг даргын Тамгын газрын "Дотоод хяналт шалгалт"-ын 2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллав. Үйл ажиллагааны хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 92.5 хувийн хэрэгжилттэй байна. Төсвийн байгууллагуудын үйл ажиллагаанд 1 удаа хяналт шалгалт хийж заавар зөвлөмж өгсөн. | 100 | |
| | 2.4. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4. Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх. | 2.4.1. Тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл болон төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухай бүр цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулах. | Сумын хэмжээнд төрийн байгууллагууд тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл болон төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухай бүр, сар бүр нэгтгэн мэдээллийн самбарт байршуулан иргэдийг мэдээллээр хангаж ажиллаж байна. Байгууллагууд www.Shilendans.gov.mn - д хугацаанд нь төсвийн зарлага, гүйцэтгэлийг шивж хэвшсэн. | 70 | |
| | | 2.4.2. Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох. (татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл) Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарын хамт мэдээлэх. | Шилэн дансны тухай хуулийн дагуу сумын төсвийн байгууллагууд төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, мэдээ тайланг байгууллагын мэдээллийн самбар, Засгийн газрын **www.Shilendans.gov.mn** сайтад байршуулж хэвшсэн. Энэ нь иргэдэд тухай бүр үнэн зөв мэдээллээр бүрэн хангах нөхцөл бүрдэж байна. Тайлант хугацаанд шилэн дансны мэдээлэлтэй холбоотой гомдол, санал иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирээгүй болно. 2020 оны төсвийн зарлагын хэтрэлт, хэмнэлтийн мэдээ, тайлан, өр авлагад дүн шинжилгээ хийж, төсвийн зардлын бүлгийн шилжүүлгийг | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | баримт бүрдүүлэн хийх болон сумын санхүүгийн дэмжлэгт өөрчлөлт оруулах төслийн санал оруулан танилцуулж 2020.10.28-нд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлуулсан. | | |
| | | 2.4.4. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хуваарилалт, хэрэгжилтийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэх, цахим хуудсанд байршуулж хэвших. | 2020 онд суманд гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр байхгүй. | Хугацаа болоогүй | |
| | 2.7. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10. Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх энэ чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх. | 2.7.1. Иргэдийн өргөдөл (санал, мэдэгдэл), гомдол, хүсэлт, мэдээлэл шуурхай хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх. (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр) | **Sant.ov.gov.mn** цахим хуудсанд одоогоор ирсэн өргөдөл, гомдол байхгүй. Сумын төсвийн байгууллагууд иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээлэл шуурхай хүлээн авах нөхцөлийг утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр бүрдүүлэн ажиллаж байна.<br>2020 оны 3-р улирлын байдлаар сумын хэмжээнд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтнуудад хандаж өссөн дүнгээр нийт 515 өргөдөл, санал ирүүлснээс шинэ төрлийн коронавирус халдвартай холбогдуулан Эрүүл мэндийн төвд ямар нэгэн өргөдөл гомдол, санал хүсэлт ирээгүй байна. Сумын ЗДТГазарт өргөдөл 491 буюу 95.3 хувь, санал 3 буюу 0.6 хувийг тус тус ээлж байгаагаас ирүүлсэн хэлбэрийн хувьд авч үзвэл бичгээр 486 буюу 98.9 хувь, биечлэн хандсан 2 буюу 0.4 хувь, утсаар 3 буюу 0.6 хувь байна. Төрийн байгууллага, албан тушаалтнуудад байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн нийт 515 өргөдөл, саналын 96.6 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 17 буюу 3.3 хувийг шийдвэрлэх хугацаа болоогүй байна, шийдвэрлэх хугацаа болоогүй өргөдлүүд халамж, тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой байв. | 100 | |
| | 2.8. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10. Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан хууль ёсны шаардлага, | 2.8.1 Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд аймгийн ЗДТГазраас хүргүүлсэн хугацаатай албан бичгийн биелэлтийг заасан хугацаанд нь | Аймгийн ЗДТГазраас ирүүлсэн хугацаатай албан бичгийн биелэлтийг заасан хугацаанд нь хүргүүлдэг. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжтэй холбогдуулан зохион байгуулалтын арга хэмжээг тухай бүр авч ажиллаж байна. | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | шийдвэрийг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан түүний дагуу холбогдох арга хэмжээг заавал авч, хариуг хугацаанд нь өгөх үүрэгтэй. | хүргүүлэх, зөвлөмжтэй холбогдуулан зохион байгуулалтын арга хэмжээ авах. | | | |
| | | 2.8.2. Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагчаас /аймгийн Засаг даргаас/ гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах мэдэгдэл болон хууль, журмын хүрээнд хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар ирүүлсэн албан бичгийн биелэлтийг тус тус шийдвэрлэн хугацаанд нь хүргүүлэх. | Тус суманд 2020 оны 12-р сарын 10-ны байдлаар Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч болон аймгийн Засаг даргаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах мэдэгдэл болон хууль, журмын хүрээнд хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар ирүүлсэн албан бичиг ирээгүй. Ирсэн нөхцөлд хугацаанд нь хүргүүлж хэвшсэн. | 100 | |
| | 2.10. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10-22 дугаар зүйлүүдэд заасан албан тушаалтанд тавигдах хориглолт хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах. | 2.10.1. Хуулийн 10 дугаар зүйлийн 10-22 дугаар зүйлүүдэд заасан албан тушаалтанд тавигдах 13 төрлийн хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарч, албан тушаалтны ХАСУМ-ийг хянасан дүгнэлтийг үндэслэн албан тушаалтанд зөвлөмж чиглэл хүргүүлж ажиллах. | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5, 23.6 дахь хэсэгт заасны дагуу 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар сумын Засаг даргаас нийт 1 (Засаг даргын орлогч) албан тушаалтны нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг эрх бүхий газарт хүргүүлж, албан үүргийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэхийг хянуулсны дараа тухайн албан тушаалд томилох үйл ажиллагаа хэвшээд байна. “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” албан даалгаврыг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100 | |
| | | 2.10.2. Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг /шинэчлэн болон шинээр томилогдсон албан тушаалтнуудын/ үнэн зөв, хуульд заасан хугацаанд гаргуулах, бүртгэх, хянах, үйл ажиллагаа зохион | Хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн чиглэлээр байгууллагын удирдах албан тушаалтнуудыг арга зүйгээр хангаж, нийт 5 мэдүүлэг гаргагч нарын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулах ажлыг зохион байгуулсан. Мэдүүлгийг засваргүй, бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгсөн эсэхэд хяналт тавьж ажиллаа. | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байгуулах. | | | |
| | | 2.10.3. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, цахим системд бүртгэх. | Байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйл заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу гаргуулан авч холбогдох шийдвэрүүдэд хавсаргадаг. | 100 | |
| | **ДУНДАЖ ОНОО** | | | **90.7** | |
| **Гурав. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд** | | | | | |
| | **Зорилт 1.** Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх. | | | | |
| | 3.1. Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх. | 3.1.1. Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх. | Тус сумын ЗДТГазарт 2020 оны жилийн эцсийн байдлаар 2 сул орон тоо байна. Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн, Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн сул орон тоог зарлуулахаар аймгийн ТАЗСЗөвлөлд холбогдох материалыг хүргүүлсэн. Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан зайлшгүй шаардлагаар төрийн албаны зөвлөлийн зөвлөмжийн дагуу 1 сул орон тоон дээр хөдөлмөрийн гэрээгээр хүн түр авч ажиллуулж байна. Хууль бус томилгоо хийгдээгүй. | 100 | |
| | | 3.1.2. Төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг тухай бүрд олон нийтэд ил тод болгох. | Тайлант онд сумын Засаг даргаас нийт 1 (Засаг даргын орлогч) албан тушаалтны нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг эрх бүхий албан тушаалтны хянасан дүгнэлтийг байгууллагынхаа цахим хуудсанд байршуулах хугацаа болоогүй. | Хугацаа болоогүй | |
| | | 3.1.3. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн баримтад хүргүүлэх баримт бичгийн жагсаалтад Төрийн албаны | Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэгт хавсаргаж хүргүүлэх баримт бичгийн жагсаалтад Засаг даргын орлогч нь улс төрийн албан тушаалтан учир бусад холбогдох материалыг хүргүүлсэн. | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | зөвлөлийн болон салбар зөвлөлийн тогтоол, дүгнэлтийг хавсаргах. | | | |
| | 3.2.Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах, нийтийн албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх. | 3.2.1. Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах. | Төрийн албаны тухай хууль болон дагалдан гарсан журмуудаар сургалт мэдээлэл хийж, цахимаар байгууллагын дарга нар болон ёс зүйн зөвлөлүүдэд хүргүүлсэн. Ажлын байран дээрээ суралцах нөхцлийг бүрдүүлж 14 хоногт 1 удаа “Мэдээллийн цаг” арга хэмжээгээр төрийн албан хаагчид мэдээлэл солилцож байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Батбаяр, туслах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад нийгмийн бодлогын мэргэжилтэн М.Тогтох нар онлайнаар суралцаж, шалгалт өгч сертификат авсан.<br>- | 70 | |
| | 3.3. Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх. | 3.3.1. Төрийн байгууллагын ёс зүйн хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх. | Төсвийн 5 байгууллага “Ёс зүйн зөвлөл” байгуулан ажиллаж байна. Ёс зүйн зөвлөлүүд 2020 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган батлуулсан. Төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын тайланг хагас бүтэн жилээр аймгийн ЗДТГ-ын ТАЗСЗөвлөлд хугацаанд нь хүргүүлсэн. | 100 | |
| | | 3.3.2. Төрийн байгууллагуудын дотоод хяналт шалгалтын нэгжийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих. | Байгууллагууд дотоод хяналт шалгалтын нэгж байгуулан ажиллаж байна. Хагас, бүтэн жилээр тайланг авч гүйцэтгэлд нь хяналт тавин, нэгтгэж аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэст хугацаанд нь хүргүүлж хэвшсэн. | 100 | |
| | **Зорилт 2.** Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх. | | | | |
| | 3.4. Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх. | 3.4.1.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах. | Тус сумын 5 байгууллага албаны мэдээ, мэдээллийг дамжуулж ашиглаж байна. Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр аймгийн Засаг даргын Тамгын газар, сумдын Засаг даргын Тамгын газарт албаны имэйл нэвтрүүлж, төрийн байгууллагууд үйл ажиллагаандаа ашиглаж байна. Азийн хөгжлийн банкны төслөөр 2019 онд сумын иргэний бүртгэлийн ажилтнуудыг онлайн сүлжээнд холбож, бүртгэлийн үйлчилгээг иргэдэд газар дээр нь чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх боломжийг | 100 | |
| | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | бүрдүүлэв. Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн эх нотлох баримт тус бүр 100 хувь цахимжив. Улсын бүртгэлийн үйлчилгээний хураамжийг **ebarimt аппликейшн** ашиглан төлбөр төлөх боломжтой болгов. Мөн улсын бүртгэлийн 18 төрлийн үйлчилгээ, 20 төрлийн лавлагааны төлбөрийг ebarimt ашиглан төлөх боломж бүрдэж, УБЕГазрын **BURTGEL.MN** сайтаар цахим архивын програмаас лавлагаа олгох, 14 төрлийн лавлагааг цахимаар хүлээн авах нөхцөл тус тус бүрдээд байна.<br><br>2020 онд төрийн үйлчилгээний нэгдсэн систем операторын үйлчилгээ нэвтэрсэн. Иргэдэд 9 байгууллагын 54 нэр төрлийн лавлагаа мэдээлэл гаргаж өгч байна. | | |
| | 3.6.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагаag иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах. | 3.6.1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх. | Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хэрэглэгчийн санал асуулга явуулж дүгнэж байна. Дутагдалтай ажлын гүйцэтгэлийг сайжруулах үүрэг чиглэлийг тухай бүр өгч ажил сайжруулж байна. | 70 | |
| | | 3.6.2. Орон нутгийн хэмжээнд хэрэгжиж буй урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд үр нөлөөний үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх. | Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хагас, бүтэн жилээр ИТХуралд тайлагнаж, дүгнүүлдэг. | 70 | |
| **Зорилт 3.**Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх. | | | | | |
| 3.7 | 3.7. Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх. | 3.7.1. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “3Г-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээллэх ажлыг зохион байгуулах. | Шилэн дансанд төсөвт байгууллагууд тухай бүр, сар, улирал, жилээр мэдээлэх мэдээг тухай бүр мэдээлж улирал бүр тайлан мэдээг илгээж хэвшээд байна. Шилэн дансны мэдээллийг Аймгийн санхүү дотоод хяналт аудитын газраас улирал бүр хяналт шалгалт хийж тайлан мэдээг сумын Засаг даргад хүргүүлдэг. Сумын ИТХ-ын тэргүүлэгчдэд төрийн сангийн мэргэжилтэн улирал бүр шилэн дансны хэрэгжилтийн тайлан гаргаж өгдөг. | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3.8 | 3.8. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлага тооцох, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх. | 3.8.1. Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах. | Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т заасан төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх гэж заасны дагуу орон нутгийн төсвийн байгууллага, бусад хамаарах салбарын төсвийн төслийн саналыг нэгтгэн авч аймгийн ЗДТГ-ын санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. Төсвийн төслийг боловсруулахдаа дээд шатны байгууллага болох аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн удирдамжийн дагуу сумын төсвийн байгууллагад төсвийн төсөл хийх аргачлал, зааврын хамт хүргүүлж төсвийн саналыг боловсруулан авч хэвшсэн болно. Орон нутгийн төсвийн төсөлд олон нийтийн саналыг тусгаснаар төсөв үндэслэлтэй хийгдэж, иргэдийн саналыг тусгасан, хэрэгцээ шаардлагад үндэслэсэн төсөв бий болсон. | 100 | |
| **Зорилт 4**.Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх. | | | | | |
| | 3.9. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх. | 3.9.1. Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах, цаашид тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулж хэвшүүлэх. | Худалдан авах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулж хэвшсэн. | 100 | |
| | | 3.9.2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүн цахим хуудсандаа байршуулах. | Тухайн онд зохион байгуулагдах худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендер шалгаруулалтын үр дүн болон хяналт, шалгалтын байгууллагуудын тайлан, дүгнэлт зэрэг мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим сайт tender.gov.mn-д нийтэлж хэвшсэн. | 100 | |
| | | 3.9.3. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн | Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх 10 гаруй мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим сайт tender.gov.mn-д тендер шалгаруулалтын үр дүнг мэдээлсэн. | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | үндэслэл, шалтгааныг цахим хуудсанд байршуулж мэдээлэх. | | | |
| **Зорилт 6.** Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх. | | | | | |
| | | | | | |
| **Зорилт 7.**Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх. | | | | | |
| | | | | | |
| **Зорилт 10.** Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх. | | | | | |
| | 3.12. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх. | 3.12.1.Төрийн байгууллагууд Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, АТҮХөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг сайжруулах. | Сумын төсвийн байгууллагууд Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. АТҮХөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг сайжруулахад анхаарч хяналт тавин, мэдээ тайланг нэгтгэн дүгнэж холбогдох байгууллагад хүргүүлж байна. | 70 | |
| **Дундаж оноо** | | | | **87** | |
| | **Нийт хувь** | | | **92.6** | |

## БУСАД ШААРДЛАГАТАЙ ТООН МЭДЭЭЛЭЛ, ТАЙЛАН

Хүснэгт-2

| д/д | **Төлөвлөгөөний хүрээнд гүйцэтгэсэн ажлын төрөл** | **Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг тоо баримтаар товч дурьдах** | | |
|---|---|---|---|---|
| 1 | Сум, байгууллагын албан ёсны ямар вэб сайтад авлигын эсрэг хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, мэдээ, мэдээлэл, жилийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг байршуулсан талаар /цахим хуудас хаяг нэр/ | Төсөв санхүүгээс шалтгаалан сумын цахим хуудсыг 2020 оны 11-р сард шинэчлэн хийлгэсэн. Сумын цахим хуудас Sant.ov.gov.mn сайтад байршуулж сурталчилсан. | 70 | |
| 2 | Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гаргасан шийдвэр /тоо/ | Сумын Засаг даргын 10 захирамж, ЗДТГ-ын даргын 5, нийт 15 шийдвэр гарч хэрэгжилтийг хангаж ажилласан. | 100 | |
| 3 | Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө | Сумын веб сайт шинээр хийлгэхэд 1000.0 төгрөг, гарын авлага материал бэлтгэх, бусад ажилд нийт 1500.0 мянган төгрөг зарцуулсан. | 100 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | Зохион байгуулсан цахим сургалтын тоо | Жилдээ 1 удаа зохион байгуулсан. | 70 | |
| 5 | Зохион байгуулсан танхимын сургалтын тоо | 2020 оны 1-р сард 1 удаа зохион байгуулсан. Цар тахлаас шалтгаалан дахин зохион байгуулж амжаагүй. | 70 | |
| 6 | Цахим болон танхимын сургалтанд хамрагдсан удирдах албан тушаалтан, төрийн албан хаагч, иргэдийн тоо | 1.удирдах албан тушаалтны тоо: 5<br>2.төрийн албан хаагчий тоо: 27<br>3. иргэдийн тоо: цахимаар хандалт 76<br>Нийт тоо: 108 | 70 | |
| 7 | Авлигын хууль тогтоомжийн чиглэлээр тараасан гарын авлага, тараах материалын тоо | Сумын ИТХ-ын 7 тэргүүлэгчид, байгууллагын 4 дарга, багийн ИНХ-д оролцсон 200 гаран иргэн, нийт 211 ширхэг гарын авлага тараасан. | 100 | |
| 8 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулага, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг материал г.м/ | АТГ-аас ирүүлсэн гарын авлагыг хэвлэн сумын ИТХ-ын 7 тэргүүлэгчид, байгууллагын 4 дарга, багийн ИНХ-д оролцсон 200 гаран иргэнд гарын авлага тараасан. Видео бичлэгийг сумын хамгийн олон дагагчтай фэйсбүүк бүлгүүдэд байршуулсан. | 70 | |
| 9 | АТҮхөтөлбөр болон Авлигын эсрэг үйл ажиллагаан жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарсан өөрчлөлт, ач холбогдол, үр дүн | Авлига болон ашиг сонирхолын зөрчилтэй холбоотой мэдээлэл ирээгүй. Байгууллагын дарга нар болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх заалтуудыг тусгаж биелэлтийг дүгнэн ажилладаг. | 100 | |
| **Дундаж оноо:** | | | **83.3%** | |

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН Г.БУЯНТОГТОХ

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА Б.АДЪЯАТОГТОХ